# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 09 дүгээр сарын 22
№ 37 (1235)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 655. | Хөрөнгийн үнэлгээний тухай /Шинэчилсэн найруулга/ | | 2615 |
| 656. | Хөрөнгийн үнэлгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 2663 |
| 657. | Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2664 |
| 658. | Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2666 |
| 659. | Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2667 |
| 660. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2668 |
| 661. | Хууль зүйн туслалцааны тухай /Шинэчилсэн найруулга/ | | 2669 |
| 662. | Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 2710 |
| 663. | Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2711 |
| 664. | Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2712 |
| 665. | Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 2713 |
| 666. | Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 2714 |
| 667. | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 2715 |


## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 668. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 108 | 2716 |
| 669. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 113 | 2716 |

## Moengo& Folo_ oa YeroehkiUlehcl Ua Jerli(

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хөрөнгийн үнэлгээ хийх, түүний зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, хяналт тавих, энэ чиглэлээр төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, үйл ажиллагаа болон үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомж

2.1.Хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Зөвшөөрлийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“гажилт” гэж тухайн үнэлгээний зүйлийн онцлог болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан үнэлгээнд ашиглаж байгаа журам, аргачлал, заавар нь үнэлгээний олон улсын стандартын зарим шаардлагаас өөр байх нөхцөл байдлыг;

3.1.2.“гуравдагч этгээд” гэж тодорхой шийдвэр гаргахад үнэлгээний тайланг, эсхүл тайланд тусгасан болон түүний үндсэн дээр тодорхойлсон үнэ цэнийг ашиглаж байгаа, эсхүл үнэлгээний тайланд тусгасан үнэ цэнэ нь тухайн этгээдийн өмчлөх эрхэд аливаа хэлбэрээр нөлөөлж байгаа этгээдийг;

---
[1]Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[2]Иргэний хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

3.1.3.“захиалагч” гэж энэ хууль болон гэрээнд заасан тохиолдолд өөрийн болон бусдын өмнөөс хөрөнгө үнэлүүлэх захиалга өгсөн этгээдийг;

3.1.4.“үйлчлүүлэгч” гэж хууль тогтоомжид заасны дагуу, эсхүл захиалагчийн санаачилгаар өөрийн эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийг үнэлүүлж байгаа хуулийн этгээд, хувь хүнийг;

3.1.5.“үнэ цэнэ” гэж хөрөнгийн үнэлгээ хийсний үр дүнд үнэлгээний зүйл дэх хувь оролцоонд тохирох эдийн засгийн үр ашгийн тооцооллын боломжит мөнгөн илэрхийллийг;

3.1.6.“үнэ цэнийн суурь” гэж үнэлгээний зорилго, зориулалтад нийцүүлэн сонгож, үнэ цэнийг тооцоолон гаргахад ашиглах урьдчилсан нөхцөлийг;

3.1.7.“үнэлгээний олон улсын стандарт” гэж Үнэлгээний олон улсын стандартын хорооноос баталсан стандартыг;

3.1.8.“үнэлгээний өдөр” гэж хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлсон өдрийг;

3.1.9.“үнэлгээний тайлан” гэж холбогдох хууль тогтоомж болон үйлчлүүлэгч, захиалагчтай хийсэн гэрээний дагуу үнэлгээчний бэлтгэн гаргасан, үнэлгээний зорилго, үнэ цэнийн суурь, он, сар, өдөр, хэрэглэсэн хандлага, арга, ашигласан мэдээллийн эх сурвалж, дэвшүүлсэн төсөөлөл, үнэ цэнийн талаарх дүгнэлт зэргийг багтаасан баримт бичгийг;

3.1.10.“үнэлгээний хуулийн этгээд” гэж хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

3.1.11.“үнэлгээчин” гэж энэ хуулийн 15.1-д заасан үнэлгээ хийх эрх авсан иргэнийг;

3.1.12.“үнэлгээчний нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа” гэж үнэлгээчний хувьд бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн зорилтот бүлгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын төлөө үзүүлж байгаа үнэлгээний үйлчилгээ, иргэний боловсролыг дэмжих зорилготой үйл ажиллагааг;

3.1.13.“хөрөнгийн үнэлгээний зүйл” гэж үнэлэгдэж байгаа эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгө, эд хөрөнгийн эрх, бизнесийн үйл ажиллагаа, шаардах эрх, өр төлбөр болон иргэний эрх зүйн харилцааны бусад зүйлийг;

3.1.14.“хөрөнгийн үнэлгээ хийх” гэж тодорхой зорилгод нийцүүлэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтоох хараат бус үйл ажиллагааг.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ

**4 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийхэд баримтлах зарчим**

4.1.Хөрөнгийн үнэлгээ хийхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хараат бус байх;
4.1.2.нууцыг хадгалах;
4.1.3.шударга байх;
4.1.4.бодитой байх;
4.1.5.хууль тогтоомж, стандартад нийцсэн байх.

4.2.Хөрөнгийн үнэлгээ хийхэд үнэлгээний олон улсын болон үндэсний стандартын дагуу бэлтгэл ажлыг хангасан байна.

4.3.Үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээд хөрөнгийн үнэлгээ хийх явцад олж авсан үйлчлүүлэгч болон захиалагчийн нууцад хамаарах мэдээллийг бичгээр зөвшөөрөл олгоогүй тохиолдолд бусдад задруулах, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахыг хориглоно.

4.4.Хөрөнгийн үнэлгээ хийхэд үнэлгээний олон улсын стандарт, энэ хуулийн 4.5, 7.2-т заасан хөрөнгийн үнэлгээний үндэсний стандарт, журам, аргачлалыг удирдлага болгоно.

4.5.Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгийн үнэлгээний үндэсний стандартыг үнэлгээний олон улсын стандартын зарчим болон энэ хуульд нийцүүлэн батална.

**5 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх үндэслэл**

5.1.Хөрөнгийн үнэлгээг дараах үндэслэлээр хийнэ:

5.1.1.үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээд нь үйлчлүүлэгч, эсхүл захиалагчтай харилцан бичгээр тохиролцсон;

5.1.2.үнэлгээчин ажил олгогчийн даалгасны дагуу хөрөнгөд үнэлгээ хийх;

5.1.3.хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр.

5.2.Нийтийн эрх ашгийг хөндсөн дараах хөрөнгийн үнэлгээг үнэлгээний хуулийн этгээдээр гүйцэтгүүлнэ:

5.2.1.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн[3] 4.2-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн үнэлгээний зүйлийг санхүүгийн тайлагналын зорилгоор үнэлэхэд;

5.2.2.төрийн болон орон нутгийн өмчийг хувьчлах, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, зээлийн барьцаанд ашиглах, өр төлбөрт тооцоход;

5.2.3.төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг шинээр байгуулах, өөрчлөн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийг өөрчлөхөд;

5.2.4.ашигт малтмалын болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгө болон байгалийн бусад баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад;

5.2.5.хөрөнгийн үнэлгээний зүйлийг төрийн болон орон нутгийн хэрэгцээнд буцаан авахад;

5.2.6.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцааг нийтэд санал болгон гаргах үед;

5.2.7.тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх тохиолдолд.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасна ас бусад хөрөнгийн үнэлгээг үнэлгээчин хийж болно.

**6 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ**

6.1.Үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээд нь үйлчлүүлэгч, эсхүл захиалагчтай харилцан тохиролцсон бол хөрөнгийн үнэлгээг гэрээний үндсэн дээр хийнэ.

6.2.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээг бичгээр байгуулна.

6.3.Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээнд дараах зүйлийг тусгана:

[3]Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

6.3.1.хөрөнгийн үнэлгээний зориулалт;

6.3.2.хөрөнгийн үнэлгээний зүйл, түүний шинж байдал;

6.3.3.талуудын эрх, үүрэг;

6.3.4.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан тухай мэдээлэл;

6.3.5.хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлс;

6.3.6.хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журам.

6.4.Үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээд нь хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ, үнэлгээний тайлан, түүнд хавсаргасан бусад баримт бичгийг архивын нэгж бүрдүүлэн 15 жил хадгална.

**7 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээ хийх журам, аргачлал**

7.1.Хөрөнгийн үнэлгээг хийхэд үнэлгээний олон улсын болон үндэсний стандарт, энэ хуулийн 7.2-т заасан хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг мөрдөнө.

7.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дангаар, эсхүл доор дурдсан төрийн байгууллагатай хамтран тухайн хөрөнгийн үнэлгээний зүйлийн шинж байдал, зориулалтад нийцсэн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг батална:

7.2.1.санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний журам, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.2.2.дуудлага худалдааны зориулалттай үнэлгээний журам, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.2.3.барьцааны зориулалттай үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк, эсхүл Санхүүгийн зохицуулах хороотой хамтран;

7.2.4.үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, нөхөх олговрын үнэлгээний журам, аргачлалыг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.5.хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.2.6.биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээний журам, аргачлалыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.7.түүхийн дурсгалт зүйл, үнэт эдлэл, эрдэнэс, ховор эд зүйлийн үнэлгээний журам, аргачлалыг Монголбанк болон соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.8.санхүүгийн хэрэгслийн журам, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.2.9.бизнесийн үнэлгээний журам, аргачлалыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран;

7.2.10.татварын зорилгоор хөрөнгийн үнэлгээний журам, загварын аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

7.2.11.баталгаажсан үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт үржлийн мал, амьтны үнэлгээний журам, аргачлалыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.12.ашигт малтмал болон газрын тосны орд, байгалийн хийн хөрөнгийн үнэлгээний журам, аргачлалыг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.13.байгалийн бусад баялгийн эдийн засгийн үнэлгээний журам, аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран;

7.2.14.төсөвт байгууллагын санхүүгийн тайлагналын зориулалттай үнэлгээний журам, аргачлалыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

**8 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тайлан**

8.1.Хөрөнгийн үнэлгээний тайлан нь үйлчлүүлэгч, захиалагч, гуравдагч этгээдэд уг үнэлгээний зүйлийн үнэ цэнийн талаар бодитой ойлголт өгөхөөр бэлтгэгдсэн байна.

8.2.Хөрөнгийн үнэлгээний тайлан дараах шаардлагад нийцсэн байна:

8.2.1.хөрөнгийн үнэлгээний үнэ цэнийн суурийг тодорхойлоход үнэлгээний ажлын нөхцөл, зорилгод тохируулан сонгосон байх;

8.2.2.хөрөнгийн үнэлгээний тайланд хөрөнгийн үнэлгээний стандарт, энэ хуулийн 3.1.1-д заасан тохиолдлын талаар

тэмдэглэж тайлбарласан байх. Аливаа гажилт нь үнэлгээний тайлангийн найдвартай байдалд нөлөө үзүүлэхгүй байх;

8.2.3.хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ зохих үндэслэлтэй, тодорхой байх.

8.3.Хөрөнгийн үнэлгээний тайлан үнэлгээний олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байх бөгөөд дараах зүйлийг тусгана:

8.3.1.үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээдийн нэр, хөрөнгийн үнэлгээ хийх эрх, зөвшөөрлийн дугаар, тусгай зөвшөөрлийн хугацаа, мэргэжлийн хариуцлагын даатгалын талаарх мэдээлэл;

8.3.2.захиалагч болон үйлчлүүлэгчийн нэр, хаяг болон шаардлагатай бусад мэдээлэл;

8.3.3.гуравдагч этгээдийн талаарх мэдээлэл;
8.3.4.хөрөнгийн үнэлгээ хийсэн үндэслэл, зориулалт;
8.3.5.үнэлгээний өдөр болон тайлан бэлтгэсэн он, сар, өдөр;
8.3.6.хөрөнгийн үнэлгээний зүйлийн төрөл, түүний шинж байдлын тодорхойлолт;

8.3.7.хөрөнгийн үнэлгээний зүйлийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын талаарх мэдээлэл;

8.3.8.хөрөнгийн үнэлгээний тайлангийн хамрах хүрээ, хязгаарлах нөхцөл;

8.3.9.хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан баримт, мэдээлэл, нотолгоо, шинжилгээ, үнэлгээний тооцоолол, түүний үндэслэл;

8.3.10.хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход хэрэглэсэн арга, тэдгээрийн нийцтэй байдал;

8.3.11.хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ;
8.3.12.хөрөнгийн үнэлгээг энэ хуульд заасан стандарт, журам, аргачлалын дагуу хийсэн талаарх үнэлгээчний мэдэгдэл.

8.4.Хөрөнгийн үнэлгээний тайланд үнэлгээчин, эсхүл үнэлгээний хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, үнэлгээчин гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байна.

**9 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлс**

9.1.Үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээд хөрөнгийн үнэлгээ хийсэн бол үйлчлүүлэгчээс үйлчилгээний хөлс авна.

9.2.Хөрөнгийн үнэлгээг энэ хуулийн 5.1.1-д заасан үндэслэлээр хийх бол үйлчилгээний хөлсийг талуудын хооронд байгуулах гэрээгээр тогтооно.

9.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан хөрөнгийн үнэлгээний үйлчилгээний хөлсний жишгийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

**10 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

10.1.Үйлчлүүлэгч дараах эрхтэй:

10.1.1.хуульд заасны дагуу эрх бүхий этгээд томилсноос бусад тохиолдолд хөрөнгийн үнэлгээ хийх үнэлгээчин, эсхүл үнэлгээний хуулийн этгээдийг сонгох;

10.1.2.хөрөнгийн үнэлгээний тайланг баталгаажуулахаас өмнө танилцах, тайлангийн талаар тайлбар авах;

10.1.3.үнэлгээчин болон үнэлгээний хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үнэлгээний тайлангийн талаар хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад 30 хоногийн дотор гомдол гаргах;

10.1.4.хөрөнгийн үнэлгээний тайлан энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан шаардлага, стандартад нийцээгүй нь тогтоогдсон тохиолдолд өөрт учирсан хохирлыг нэхэмжлэх;

10.1.5.гэрээгээр тохирсон бусад.

10.2.Үйлчлүүлэгч дараах үүрэгтэй:

10.2.1.хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай үнэн зөв баримт, мэдээллээр үнэлгээчнийг хангах;

10.2.2.үнэлгээний үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах;

10.2.3.хөрөнгийн үнэлгээ хийхэд дарамт шахалт үзүүлэхгүй, хөндлөнгөөс оролцохгүй, саад учруулахгүй байх;

10.2.4.үнэлгээний найдвартай байдалд нөлөөлөхүйц мэдээллийг нуун дарагдуулахгүй байх;

10.2.5.үнэлгээ хийлгэсэн үйлчилгээний хөлсийг гэрээний дагуу төлөх;

10.2.6.гэрээгээр тохирсон бусад.

10.3.Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан эрх, 10.2.3, 10.2.4, 10.2.5-д заасан үүрэг захиалагч, гуравдагч этгээдэд нэгэн адил хамаарна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ҮНЭЛГЭЭЧИН

### 11 дүгээр зүйл.Үнэлгээчний эрх

11.1.Үнэлгээчин дараах эрхтэй:

11.1.1.хөрөнгийн үнэлгээ хийхэд шаардлагатай үнэн зөв баримт, мэдээллээр хангахыг үйлчлүүлэгчээс шаардах;

11.1.2.үйлчлүүлэгч хөрөнгийн үнэлгээний зүйлийн тухай шаардлагатай мэдээллээр хангаагүй, гэрээнд заасан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх болон түүний хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөхгүй байх үүргээ биелүүлээгүй бол хөрөнгийн үнэлгээ хийхээс татгалзах;

11.1.3.энэ хуулийн 5.1.3-т заасны дагуу үнэлгээ хийж байгаа нөхцөлд зайлшгүй шаардлагатай баримт, мэдээллийг гаргуулан авахын тулд төрийн эрх бүхий байгууллага, түүний холбогдох албан тушаалтанд үйлчлүүлэгчийн хамт хүсэлт гаргах;

11.1.4.хөрөнгийн үнэлгээ хийхэд бусад үнэлгээчин болон мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах;

11.1.5.хууль тогтоомжид заасан бусад.

### 12 дугаар зүйл.Үнэлгээчний үүрэг

12.1.Үнэлгээчин дараах үүрэгтэй:

12.1.1.үнэлгээчний ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх;

12.1.2.хөрөнгийн үнэлгээ хийх явцад үйлчлүүлэгч болон гуравдагч этгээдээс авсан баримт бичгийн бүрэн бүтэн байдлыг хангах;

12.1.3.хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн түвшинд, хууль тогтоомж, үнэлгээний олон улсын болон үндэсний стандарт, холбогдох журам, аргачлалын дагуу явуулах;

12.1.4.хөрөнгийн үнэлгээ хийх явцад олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад мэдээлэхээс татгалзах;

12.1.5.өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;

12.1.6.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдах;

12.1.7.хөрөнгийн үнэлгээний тайланг энэ хуулийн 8.2-т заасан шаардлагад нийцүүлэн гаргах;

12.1.8.энэ хуулийн 25.2-т заасан мэдээллийг хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санд оруулах;

12.1.9.үнэлгээчний мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

12.1.10.хууль тогтоомжид заасан бусад.

**13 дугаар зүйл.Үнэлгээний хараат бус байдал**

13.1.Үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд нь захиалагч, үйлчлүүлэгч, гуравдагч этгээдээс ажил төрөл, хувийн харилцаа холбооны хувьд хараат бус байна.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан хараат бус байдлыг хангахын тулд үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно:

13.2.1.үнэлгээчин нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн[4] 3.1.8, 3.1.9-д заасан хандив, бэлгийг үйлчлүүлэгч, захиалагч, гуравдагч этгээдээс авахыг;

13.2.2.үйлчилгээний үнэ хөлсийг үнэлгээний зүйлийн үнийн дүнгээс шалтгаалан өөрчлөх, эсхүл тодорхой хувиар тогтоохыг;

13.2.3.үйлчлүүлэгчтэй Компанийн тухай хуулийн[5] 99.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээд байхыг;

[4]Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаарт нийтлэгдсэн.
[5]Компанийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 42 дугаар нийтлэгдсэн.

13.2.4.үйлчлүүлэгчид аудитын үйлчилгээ үзүүлсэн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн[6] 4.1.30.а-д заасан холбогдох этгээд байхыг;

13.2.5.хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ байгуулахаас өмнөх 24 сарын хугацаанд үйлчлүүлэгчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байхыг;

13.2.6.үйлчлүүлэгч, захиалагч нь үнэлгээний хуулийн этгээдийн тухайн жилийн санхүүгийн тайланд аудитын үйлчилгээ үзүүлэхийг.

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан хараат бус байх нөхцөл, шаардлагыг зөрчсөн гэж үзвэл захиалагч, үйлчлүүлэгч болон гуравдагч этгээд хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад хандан гомдол гаргах эрхтэй.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ҮНЭЛГЭЭЧНИЙ ЭРХ БОЛОН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

### 14 дүгээр зүйл.Үнэлгээчний эрх олгох шалгалтад орох этгээдэд тавигдах шаардлага, шалгалт зохион байгуулах

14.1.Үнэлгээчний эрх олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүн, шалгалт зохион байгуулах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

14.2.Үнэлгээчний эрх олгох шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа товлон зарлана.

14.3.Дараах шаардлагыг хангасан иргэн үнэлгээчний эрх олгох шалгалтад оролцох эрхтэй:

14.3.1.дээд боловсролтой;
14.3.2.мэргэжлээрээ хоёр ба түүнээс дээш жил ажилласан;
14.3.3.хөрөнгийн үнэлгээний сургалтад хамрагдсан байх.

[6]Үнэт цаасны зах зээлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

**15 дугаар зүйл.Үнэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

15.1.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага энэ хуулийн 14.1-д заасны дагуу шалгалтын дүнг үндэслэн үнэлгээчний эрхийг иргэнд гурван жилийн хугацаагаар олгоно.

15.2.Үнэлгээчний эрх эзэмшигчид гэрчилгээ, тэмдэг олгох бөгөөд уг гэрчилгээ, тэмдгийн загварыг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага батална.

15.3.Үнэлгээчин үнэлгээчний эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хугацаа сунгуулах өргөдөл гаргах эрхтэй.

15.4.Үнэлгээчний эрхийн хугацаа сунгуулах тухай өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

15.4.1.“Хөрөнгийн үнэлгээчин” гэрчилгээний хуулбар;
15.4.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

15.5.Мэргэжлийн болон Ёс зүйн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага үнэлгээчний эрхийг гурван жилийн хугацаагаар нэг удаа сунгана.

15.6.Үнэлгээчний эрхийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

15.6.1.үнэлгээчин энэ хуулийн 12.1.3, 12.1.4, 12.1.7, 13.2-т заасан үүрэг, шаардлагыг биелүүлээгүй бол үнэлгээчний эрхийг зургаан сараар;
15.6.2.энэ хуулийн 15.6.1-д заасан үнэлгээчний эрхийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд үнэлгээчний эрхийг сэргээнэ.

15.7.Дараах тохиолдолд үнэлгээчний эрхийг хүчингүй болгоно:

15.7.1.үнэлгээчин хүсэлт гаргасан;
15.7.2.түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, үнэлгээчний эрхийг сэргээлгэх тухай хүсэлт ирүүлээгүй;

15.7.3.үнэлгээчний эрхийг сунгуулах тухай хүсэлт гаргаагүй;
15.7.4.энэ хуулийн 15.6.1-д заасан зөрчлийг давтан гаргасан;
15.7.5.иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон;

15.7.6.үнэлгээчин гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон.

15.8.Хөрөнгийн үнэлгээчний эрхийг сунгаснаас хойш энэ хуулийн 12.1-д заасан үүргээ биелүүлсэн тохиолдолд үнэлгээчинд хөрөнгийн үнэлгээ хийх эрхийг хугацаагүй олгоно.

15.9.Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагаас үнэлгээчний эрх авсан Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнд үнэлгээчний эрх олгох шаардлагыг энэ хуулийн 14.1-д заасан журмаар зохицуулна.

15.10.Энэ хуулийн 15.6.1-д зааснаас бусад тохиолдолд үнэлгээчинд үнэлгээчний ёс зүйн дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**16 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, түүнд тавигдах нөхцөл, шаардлага**

16.1.Үнэлгээний хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг эрхэлнэ.

16.2.Үнэлгээний хуулийн этгээд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

16.2.1.хоёроос доошгүй үндсэн орон тооны үнэлгээчинтэй байх бөгөөд гүйцэтгэх захирал нь үнэлгээчний хугацаагүй эрх авсан байх;

16.2.2.үйл ажиллагаа явуулах ажлын байр, техник хэрэгслээр хангагдсан байх;

16.2.3.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхэлдэг байх;

16.2.4.мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх;

16.2.5.үнэлгээний олон улсын болон үндэсний стандарт, журам, аргачлалд нийцсэн журамтай байх;

16.2.6.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь гадаадын иргэн, хуулийн этгээд бол нийт хувьцааны гуравны нэгээс доошгүй хувийг Монгол Улсын иргэн үнэлгээчин эзэмшдэг байх;

16.2.7.үнэлгээний хуулийн этгээдийн нийт хувьцааны гуравны хоёроос доошгүй хувийг энэ хуулийн 3.1.11-д заасан эрх авсан иргэн эзэмшдэг байх;

16.2.8.жилд нэгээс доошгүй удаа үнэлгээний нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан байх;

16.2.9.үнэлгээний хуулийн этгээд тухайн жилд хийсэн үнэлгээний ажлын жагсаалт, оролцсон үнэлгээчин, шинжээч, туслахын нэрийг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад цахимаар хүргүүлнэ.

16.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэрчилгээ олгох бөгөөд уг гэрчилгээний загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.4.Үнэлгээний хуулийн этгээд салбартай байж болох бөгөөд салбарт үндсэн орон тооны нэгээс доошгүй үнэлгээчинтэй байна. Салбарын гүйцэтгэх захиралд энэ хуулийн 8.4 дэх хэсэг хамаарахгүй.

**17 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох**

17.1.Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч энэ хуулийн 16.2-т заасан нөхцөл, шаардлагыг хангасан гэж үзвэл дараах баримт бичгийг бүрдүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

17.1.1.тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;
17.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
17.1.3.үнэлгээний хуулийн этгээдийн дүрэм;
17.1.4.энэ хуулийн 16.2.5-д заасан журам;
17.1.5.үнэлгээчний дэлгэрэнгүй анкет;
17.1.6.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаас авсан үнэлгээчний ёс зүйн талаарх тодорхойлолт;

17.1.7.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
17.1.8.мэдээллийн технологи, аюулгүй байдлын дотоод журам.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан баримт бичиг нь шаардлага хангасан гэж үзвэл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар олгоно.

17.3.Тусгай зөвшөөрөл авсан үнэлгээний хуулийн этгээд “Үнэлгээ” гэсэн үгийг оноосон нэрийн ард хэрэглэнэ.

17.4.Үнэлгээний хуулийн этгээдийн үндсэн орон тооны үнэлгээчин бусад үнэлгээний хуулийн этгээдэд гэрээгээр ажиллахыг хориглоно.

**18 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах**

18.1.Үнэлгээний хуулийн этгээд нь хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө зөвшөөрөл сунгуулах тухай өргөдлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

18.2.Энэ хууль болон зөвшөөрлийн хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагыг хангасан, тогтоосон стандарт, журам, аргачлалыг мөрдөж ажилласан тохиолдолд үнэлгээний хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаагаар сунгана.

18.3.Хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

18.3.1.тусгай зөвшөөрөл сунгуулах тухай өргөдөл;
18.3.2.үндсэн орон тоонд ажиллаж байгаа үнэлгээчний нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;
18.3.3.үнэлгээчний ёс зүйн тодорхойлолт;
18.3.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;
18.3.5.татварын өргүй байх.

18.4.Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

**19 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх**

19.1.Дараах тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тусгай зөвшөөрлийн хугацааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

19.1.1.энэ хуулийн 16.2-т заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа нь тогтоогдсон;

19.1.2.энэ хуулийн 17.3-т заасныг зөрчсөн үнэлгээний хуулийн этгээдийг.

19.2.Үнэлгээний хуулийн этгээдийн үйл ажиллагааг түдгэлзүүлсэн хугацаанд шинээр хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ байгуулахыг хориглох

бөгөөд өмнө байгуулсан гэрээний дагуу үүргээ биелүүлэхээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн уг зөвшөөрлийг сэргээнэ.

**20 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

20.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

20.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
20.1.2.тусгай зөвшөөрлийг авахад хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

20.1.3.хөрөнгийн үнэлгээг үнэлгээний олон улсын болон үндэсний стандарт, журам, аргачлалын дагуу хийж гүйцэтгээгүй;

20.1.4.энэ хуулийн 16.2-т заасан нөхцөл, шаардлагыг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн;

20.1.5.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

20.1.6.хөрөнгийн үнэ цэнийг бодитой бус тогтоосноор үйлчлүүлэгч, гуравдагч этгээдэд хохирол учруулсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

20.1.7.үнэлгээний хуулийн этгээдэд хийх чанарын хяналтыг гүйцэтгэхэд ажлын байр, баримт бичиг, бусад шаардлагатай мэдээлэл гаргаж өгөөгүй, үзүүлэхээс зайлсхийсэн.

**21 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих**

21.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөрөнгийн үнэлгээний хууль тогтоомжийн хэрэгжилтэд дараах байдлаар хяналт тавина:

21.1.1.хөрөнгийн үнэлгээний хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

21.1.2.үнэлгээний хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

21.1.3.хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

21.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

### 22 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага

22.1.Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллага /цаашид “Мэргэжлийн байгууллага” гэх/ нь үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдийн гишүүнчлэлтэй, мэргэжлийн ёс зүй, хараат бус байдлыг хангах, үнэлгээчинд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий нийтийн эрх зүйн хуулийн этгээд мөн.

22.2.Мэргэжлийн байгууллагын дэргэд үнэлгээчний мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан тухай иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий Мэргэжлийн болон Ёс зүйн зөвлөл ажиллана.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан Мэргэжлийн болон Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Мэргэжлийн байгууллага батална.

22.4.Мэргэжлийн байгууллага нь дүрэмтэй байна.

22.5.Мэргэжлийн байгууллагын санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

22.5.1.гишүүнчлэлийн хураамж, хандив, тусламж;
22.5.2.мэргэжлийн шалгалтын хураамж, сургалтын төлбөр;
22.5.3.захиалгаар гүйцэтгэсэн ажлын төлбөр;
22.5.4.хэвлэн нийтлэлийн орлого;
22.5.5.үнэлгээний мэдээлэл болон үйлчилгээний төлбөр.

### 23 дугаар зүйл.Мэргэжлийн байгууллагын чиг үүрэг

23.1.Мэргэжлийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалт, зөвлөгөө, мэдээллээр хангах;
23.1.2.үнэлгээчний эрх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

23.1.3.үнэлгээчнийг бэлтгэх, эрх олгох, сунгах, мэргэшүүлэх сургалт, шалгалтыг зохион байгуулах;

23.1.4.үнэлгээний үндэсний стандартыг боловсруулах, олон улсын стандартыг орчуулах, хэрэглээний тайлбар, зөвлөмж гаргах;

23.1.5.олон улсын хөрөнгийн үнэлгээний тайлагналын стандартын загвар, зааврыг үндэсний онцлогт тохируулан боловсруулан гаргах;

23.1.6.үнэлгээчний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах;

23.1.7.энэ хуулийн 25.1-д заасан хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлж ажиллуулах;

23.1.8.хөрөнгийн үнэлгээ хийх чиглэлээр мэргэшсэн, тэргүүлэх үнэлгээчний зэрэг олгох, түдгэлзүүлэх, цуцлах;

23.1.9.үнэлгээний тайланд хийсэн магадалгааг хянаж, дүгнэлт гаргах.

**24 дүгээр зүйл.Мэргэжлийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт**

24.1.Мэргэжлийн байгууллага нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн хувьд түүний удирдлага, зохион байгуулалтыг энэ хуулиар тогтооно.

24.2.Мэргэжлийн байгууллагын эрх барих дээд байгууллага нь Их хурал байна.

24.3.Их хурал Мэргэжлийн байгууллагын гишүүдийн төлөөллөөс бүрдэх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.3.1.Мэргэжлийн байгууллагын дүрэм, үнэлгээчний ёс зүйн дүрэм, гишүүнчлэлийн журмыг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

24.3.2.үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх;

24.3.3.удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;

24.3.4.гишүүнчлэлийн хураамжийн хэмжээг тогтоох;

24.3.5.хууль тогтоомжид заасан бусад.

24.4.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг дөрвөн жилд нэг удаа хуралдуулна.

24.5.Их хурлаас 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр удирдах зөвлөлийг дөрвөн жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүний бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл болох гурваас доошгүй үнэлгээчин байна.

24.6.Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.6.1.ээлжит болон ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулах;

24.6.2.үйл ажиллагааны бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

24.6.3.жилийн төсвийг баталж, санхүүгийн тайланг хэлэлцэх;

24.6.4.удирдах зөвлөлөөс тэргүүнийг сонгох, чөлөөлөх, түүний цалингийн хэмжээг тогтоох;

24.6.5.гүйцэтгэх захирлыг тэргүүний санал болгосноор томилох, чөлөөлөх, гэрээ байгуулах эрх олгох;

24.6.6.гүйцэтгэх захирлын цалин, урамшууллын хэмжээ, ажлын албаны бүтэц, орон тоог батлах;

24.6.7.салбар хороо, холбоодыг байгуулах, нэгтгэх, татан буулгах, гишүүнээр элсүүлэх, хасах, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг батлах;

24.6.8.Мэргэжлийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг батлах.

24.7.Удирдах зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

24.8.Мэргэжлийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын албатай байх бөгөөд гүйцэтгэх захирал ажлын албаны үйл ажиллагааг удирдлагаар хангана.

24.9.Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.9.1.ажлын албаны орон тоо, төсөв, гүйцэтгэл, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах;

24.9.2.ажлын албаны орон тооны ажилтныг томилох, чөлөөлөх;

24.9.3.Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх;

24.9.4.Мэргэжлийн байгууллагыг төлөөлөх, гадаад, дотоодын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах;

24.9.5.хууль тогтоомжид заасан бусад.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 25 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан

25.1.Мэргэжлийн байгууллага нь үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийг тогтооход ашиглах зорилгоор хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлнэ.

25.2.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

25.2.1.зах зээлийн үнийн судалгааны байгууллагаас гаргасан мэдээ, мэдээлэл;

25.2.2.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээсэн зах зээлийн үнэ, ханшийн талаарх мэдээ, мэдээлэл;

25.2.3.үнэлгээчний хийсэн хөрөнгийн үнэлгээний зүйлийн үнэ цэнийн талаарх мэдээлэл;

25.2.4.эд хөрөнгийн бүртгэлийн цахим мэдээллийн сангаас авсан мэдээлэл;

25.2.5.хөрөнгийн үнэлгээнд ашиглаж болох бусад мэдээ, мэдээлэл.

25.3.Хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон журмыг Засгийн газар батална.

**26 дугаар зүйл.Үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх этгээдийн мэргэжлийн хариуцлагын даатгал**

26.1.Үнэлгээний үйл ажиллагаанд алдаа гаргасны улмаас холбогдох этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулна.

26.2.Үнэлгээний үйл ажиллагааг эрхлэх үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд нь даатгалын байгууллагыг өөрөө сонгоно.

26.3.Мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамжийн хэмжээг үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд болон даатгалын байгууллага харилцан тохиролцож тогтооно.

26.4.Мэргэжлийн хариуцлагын даатгалын хураамжийн доод хэмжээг Мэргэжлийн байгууллага тогтооно.

26.5.Үйлчлүүлэгч, захиалагчийн тусгайлсан шаардлагаар тухайн үнэлгээний ажлыг мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулж болно.

**27 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

27.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[7], эсхүл Зөрчлийн тухай хуульд[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд[9] заасан хариуцлага хүлээлгэнэ.

**28 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

28.1.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл авсан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор энэ хуульд нийцүүлэн үнэлгээчний эрхээ сунгуулах, шинэчлэх тухай хүсэлт гаргана.

**29 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

29.1.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

[7]Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[8]Зөрчлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.
[9]Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠗ - ᠤ ᠡᠳᠦᠷ　　　　ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

### [illegible] ᠤᠨ [illegible] ᠤ ᠬᠠᠤᠯᠢ
\ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ \

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠪᠦᠯᠦᠭ
ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠯ

᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠣᠷᠢᠯᠲᠠ

᠑.᠑. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ [illegible] ᠃

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ [illegible] ᠤᠨ [illegible] ᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠮᠵᠢ

᠒.᠑. [illegible] ᠤᠨ [illegible] ᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠮᠵᠢ ᠨᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠬᠠᠤᠯᠢ[1] ᠂ [illegible] ᠤ ᠬᠠᠤᠯᠢ[2] ᠂ [illegible] ᠃

᠒.᠒. [illegible] ᠃

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠦᠢᠯᠡᠴᠢᠯᠡᠬᠦ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ

᠓.᠑. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ [illegible] ᠄

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠕.᠒.᠒. ᠬᠠᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠠᠴᠠ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠵᠤ᠂ ᠲᠡᠷᠡ ᠶᠢᠨ ᠪᠤᠷᠤᠭᠤ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠬᠤ ᠲᠠᠢ᠂ ᠰᠢᠨᠡ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠪᠣᠯ᠂ ᠰᠢᠯᠭᠠᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠬᠤ ᠪᠣᠯ᠂ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠪᠠᠭᠤᠯᠭᠠᠬᠤ ᠪᠣᠯ᠂

᠕.᠒.᠓. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠤᠨ ᠲᠣᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠦᠨᠡᠨ ᠵᠦᠢ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ ᠲᠣᠳᠤᠷᠬᠠᠢᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠰᠢᠭᠠᠷᠳᠠᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠨᠢ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ᠂ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢ ᠬᠤᠳᠠᠯ ᠪᠣᠯᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯ᠂ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠯᠪᠡᠷᠢ ᠶᠢ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯ᠂

᠕.᠒.᠔. ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢ ᠦᠨᠡᠨ ᠳᠦ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯ᠂ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠦᠷᠢᠳᠭᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ᠂ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯ᠂

᠕.᠒.᠕. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠤᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠲᠠᠢ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠣᠬᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯ᠂

᠕.᠒.᠖. ᠬᠠᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠤᠶᠤ ᠬᠠᠷᠢᠶ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠮᠡᠳᠡᠯ ᠦᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠡᠷᠬᠢ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠤᠷᠢᠶᠠᠩᠭᠤᠢᠯᠠᠬᠤ ᠲᠠᠢ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ ᠪᠣᠯ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠪᠣᠯ᠂

᠕.᠒.᠗. ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠤᠬᠠᠭᠠᠨ ᠤ ᠰᠢᠨᠵᠢᠯᠡᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠤᠪᠢ ᠶᠢᠨ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠨᠢᠭᠤᠴᠠ ᠲᠠᠢ ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠠᠬᠤ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠪᠣᠯ᠂ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠬᠠᠮᠢᠶᠠᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠪᠣᠯ::

᠕.᠓. ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠕.᠒-ᠲᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ ᠠᠴᠠ ᠪᠤᠰᠤᠳ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠳᠤ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠨ᠎ᠡ::

᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ:: ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ

᠖.᠑. ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠪᠠ ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠢᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠠᠭᠠᠭᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠯ ᠡᠴᠡ ᠬᠦᠯᠢᠶᠡᠨ ᠠᠪᠴᠤ᠂ ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠡᠬᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠳᠤ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠲᠣᠭᠲᠠᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠪᠦᠷᠢᠳᠬᠡᠬᠦ ᠶᠢ::

᠖.᠒. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠢ ᠦᠭᠡᠷ ᠲᠡᠭᠦᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ::

᠖.᠓. ᠪᠠᠷᠢᠮᠲᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠰᠠᠩ ᠳᠤ ᠬᠠᠳᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠵᠢᠭᠠᠮ ᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠨ᠎ᠠ:

[illegible]

᠗.᠒.᠔ · [illegible]

᠗.᠒.᠕ · [illegible]

᠗.᠒.᠖ · [illegible]

᠗.᠒.᠗ · [illegible]

᠗.᠒.᠘ · [illegible]

᠗.᠒.᠙ · [illegible]

᠗.᠒.᠑᠐ · [illegible]

᠗.᠒.᠑᠑ · [illegible]

᠗.᠒.᠑᠒ · [illegible]

᠗.᠒.᠑᠓ · [illegible]

6.2.19. [illegible]

7 [illegible]

7.1. [illegible]

7.2. [illegible]:

7.2.1. [illegible]

7.2.2. [illegible]

7.2.3. [illegible]

7.3. [illegible]:

7.3.1. [illegible]

7.3.2. [illegible]

8.3.3. [illegible]

8.3.4. [illegible]

8.3.5. [illegible]

8.3.6. [illegible]

8.3.7. [illegible]

8.3.8. [illegible]

8.3.9. [illegible]

8.3.10. [illegible]

8.3.11. [illegible]

8.3.12. [illegible]

8.4. [illegible]

9 [illegible]

9.1. [illegible]

9.2. [illegible] 5.1.1 - [illegible]

9.3. [illegible] 5.1.3 - [illegible]

10 [illegible]

10.1. [illegible]:

10.1.1. [illegible]

10.1.2. [illegible]

10.1.3. [illegible]

10.1.4. [illegible]

10.1.5. [illegible]

10.2. [illegible]:

10.2.1. [illegible]

10.2.2. [illegible]

10.2.3. [illegible]

10.2.4. [illegible]

[illegible]

᠑᠓·᠒ · ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠓·᠑ – ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible] ᠄

᠑᠓·᠒·᠑ · [illegible] ᠂ [illegible] ᠂ [illegible] ᠂ [illegible] ᠓·᠑·᠗ · ᠓·᠑·[illegible] – ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠓·᠒·᠒ · [illegible] ᠂ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠓·᠒·᠓ · [illegible] ᠑·᠑ – ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠓·᠒·᠔ · [illegible] ᠔·᠑·᠓᠐ · [illegible] – ᠳᠦ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠓·᠒·᠕ · [illegible] ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠒᠕ [illegible] ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠓·᠒·᠖ · [illegible] ᠃

᠑᠓·᠓ · ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠓·᠒ – ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible] ᠃

[illegible]

᠑᠖ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ .. [illegible]

᠑᠖.᠑. [illegible] ..

᠑᠖.᠒. [illegible] ..

᠑᠖.᠓. [illegible] :

᠑᠖.᠓.᠑. [illegible]

᠑᠖.᠓.᠒. [illegible]

᠑᠖.᠓.᠓. [illegible]

᠑᠗ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ .. [illegible]

᠑᠗.᠑. [illegible] ..

᠑᠗.᠒. [illegible] ..

᠑᠗.᠓. [illegible] ..

᠑᠕.᠔. [illegible]:

᠑᠕.᠔.᠑. « [illegible] » [illegible].

᠑᠕.᠔.᠒. [illegible]።

᠑᠕.᠕. [illegible]።

᠑᠕.᠖. [illegible]:

᠑᠕.᠖.᠑. [illegible] ᠑᠒.᠑.᠓, ᠑᠒.᠑.᠔, ᠑᠒.᠑.᠗, ᠑᠓.᠒-[illegible] [illegible].

᠑᠕.᠖.᠒. [illegible] ᠑᠕.᠖.᠑-[illegible] [illegible]።

᠑᠕.᠗. [illegible]:

᠑᠕.᠗.᠑. [illegible].

᠑᠕.᠗.᠒. [illegible].

᠑᠕.᠗.᠓. [illegible].

᠑᠕.᠗.᠔. [illegible] ᠑᠕.᠖.᠑-[illegible] [illegible].

᠑᠕.᠗.᠕. [illegible].

᠑᠕.᠗.᠖. [illegible]።

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠕᠕.᠑.᠓. [illegible] ᠦᠨ [illegible] ᠶᠢᠨ [illegible] ;
᠕᠕.᠑.᠕. ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ [illegible] ᠶᠢᠨ [illegible], [illegible] ᠶᠢᠨ [illegible] ;
᠕᠕.᠑.᠖. [illegible] ᠤᠨ [illegible], [illegible], [illegible] ;

᠕᠕.᠑. ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] :
᠕᠕.᠔. ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ [illegible] ::

ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ [illegible] ::
᠕᠕.᠓. [illegible] ᠕᠕.᠕ – [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ [illegible], [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ

[illegible] ::
᠕᠕.᠕. ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ [illegible], [illegible]

[illegible] ::
[illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ [illegible], [illegible], [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ, [illegible]
᠕᠕.᠖. [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ / [illegible] « ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ » [illegible] / [illegible], [illegible]

᠕᠕ [illegible] :: [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ

[illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ
[illegible]

᠕᠖.᠖.᠔. [illegible] ::

[illegible]
᠕᠖.᠖.᠓. [illegible] ᠰᠤᠩᠭᠤᠭᠤᠯ ᠤᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ [illegible], [illegible]

[illegible]

[illegible] ::

᠔᠖.᠔. [illegible]
[illegible] ::

᠔᠖.᠕. [illegible]

᠔᠖ [illegible] :: [illegible]
[illegible] ::

᠔᠑.᠓. [illegible]

᠔᠑.᠔.᠑. [illegible] ::
᠔᠑.᠔.᠒. [illegible] .
᠔᠑.᠔.᠓. [illegible] .
᠔᠑.᠔.᠔. [illegible] .
᠔᠑.᠔.᠕. [illegible] .

᠔᠑.᠔. [illegible] :

[illegible] ::

᠔᠑.᠕. [illegible]

᠔᠑ [illegible] :: [illegible]

[illegible]
[illegible]

16.3. [illegible]

16.4. [illegible]

16.5. [illegible]

17 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible]

17.1. [illegible]

17.2. [illegible]

18 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ [illegible]

18.1. [illegible]

19 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠬᠦ

19.1. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ 2023 ᠣᠨ ᠤ 09 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 01-ᠦ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠃ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠳᠤᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

2022 ᠣᠨ ᠤ 06 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 17 - ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ
ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

1 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ 2010 ᠣᠨ ᠤ 01 ᠳᠦᠭᠡᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 21 - ᠨ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠳᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠳᠤᠭᠠᠢ ᠃

2 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 11.27 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“**11.27 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хууль зөрчих**

1.Хөрөнгийн үнэлгээ хийлгэж байгаа үйлчлүүлэгч, захиалагч, гуравдагч этгээд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс зайлсхийсэн, эсхүл үнэлгээний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, саад учруулсан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээдийн хараат бус байдлыг хангаагүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хөрөнгийн үнэлгээний хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлагыг зөрчсөн бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Үнэлгээний хуулийн этгээдийн үндсэн орон тооны үнэлгээчин бусад үнэлгээний хуулийн этгээдэд гэрээгээр ажилласан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Салбарт үндсэн орон тооны нэгээс доошгүй үнэлгээчинтэй байх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

[illegible]　　　　ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

[illegible] ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ [illegible] ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ። [illegible]

«᠑᠑.᠒ [illegible]

᠑ · [illegible]

᠒ · [illegible]

᠓ · [illegible]

᠔ · [illegible]

᠕ · [illegible]

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ። [illegible]

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ　　　　ᠭ · ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “хөрөнгийн үнэлгээ хийх,” гэснийг, мөн зүйлийн 9.5 дахь хэсгийн “хөрөнгийн үнэлгээ,” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠗ - ᠨᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠠᠤᠳᠢᠲ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠠᠤᠳᠢᠲ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠙ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠙.᠓ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠭᠡ ᠬᠢᠬᠦ᠂» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ᠂ ᠮᠥᠨ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠙.᠕ ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠦᠨ «ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠭᠡ᠂» ᠭᠡᠰᠡᠨ ᠢ ᠲᠤᠰ ᠲᠤᠰ ᠬᠠᠰᠤᠭᠰᠠᠭᠠᠢ᠃

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠭᠡ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“19.1.5.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-500 000 төгрөг;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠗ – ᠤ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠬᠤᠷᠢᠶᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠤᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠲᠡᠮᠳᠡᠭᠲᠦ ᠶᠢᠨ ᠬᠤᠷᠢᠶᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠙ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠙᠂᠑᠂᠕ ᠳᠠᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠳᠤᠰᠤᠨ ᠢᠶᠠᠷ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠤᠭᠠᠢ᠄

《᠑᠙᠂᠑᠂᠕᠂ ᠡᠳ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠡᠷᠬᠢᠯᠡᠬᠦ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠵᠥᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠯ ᠣᠯᠭᠣᠬᠤ ᠳᠤ ᠒᠐᠐ ᠐᠐᠐ – ᠕᠐᠐ ᠐᠐᠐ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ᠃》

᠒ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠡᠳ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠨ ᠮᠦᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

## АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.4.9.хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх;”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгийн үнэлгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠖ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠑᠗ - ᠨ ᠦ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠠᠵᠤ ᠠᠬᠤᠢ ᠶᠢᠨ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠵᠥᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

᠑ ᠳ᠋ᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠠᠵᠤ ᠠᠬᠤᠢ ᠶᠢᠨ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠬᠠᠢ ᠵᠥᠪᠰᠢᠶᠡᠷᠡᠯ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠕ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ ᠑᠕.᠔.᠙ ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠠᠳᠤᠭᠰᠠᠨ ᠢᠶᠠᠷ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠤᠭᠠᠢ᠄

《᠑᠕.᠔.᠙. ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠦᠢᠯᠡ ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠡᠷᠬᠢᠯᠡᠬᠦ᠂》

᠒ ᠳ᠋ᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠄ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠥᠷᠥᠩᠭᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтооход оршино.

### 2 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж

2.1.Хууль зүйн туслалцааны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль[2], Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль[3], Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[4], Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[5], Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль[6], Өмгөөллийн тухай хууль[7], энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

---

[1]Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[2]Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн.
[3]Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.
[4]Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 08 дугаарт нийтлэгдсэн.
[5]Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.
[6]Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.
[7]Өмгөөллийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 49 дугаарт нийтлэгдсэн.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхтэй холбогдох харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1.6-д зааснаас бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг томилон оролцуулахтай холбогдох харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.

**4 дүгээр зүйл.Хууль зүйн туслалцааны зарчим**

4.1.Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх /цаашид “хууль зүйн туслалцаа” гэх/ үйл ажиллагаанд хуульчийн мэргэжлийн болон өмгөөллийн үйл ажиллагааны зарчмаас гадна дараах зарчмыг баримтална:

4.1.1.мэргэшсэн, тогтвортой байх;
4.1.2.чанартай, хүртээмжтэй байх;
4.1.3.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
4.1.4.улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА

**5 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны төрөл**

5.1.Хууль зүйн туслалцаа нь дараах төрөлтэй байна:

5.1.1.хууль зүйн зөвлөгөө өгөх;
5.1.2.өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;
5.1.3.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх.

5.2.Хууль зүйн зөвлөгөө нь дараах хэлбэртэй байна:

5.2.1.хууль зүйн асуудлаар биечлэн, цахимаар болон харилцаа холбооны хэрэгслээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;

5.2.2.хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх боловсруулах.

Тайлбар:Энэ хуульд заасан “хууль зүйн ач холбогдол бүхий баримт бичиг” гэж өргөдөл, гомдол, хүсэлт, нэхэмжлэл, тайлбарыг ойлгоно.

5.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**6 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах хүн**

6.1.Доор дурдсан хүн /цаашид “үйлчлүүлэгч” гэх/-д энэ хуульд заасан журмын дагуу өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлнэ:

6.1.1.Эрүүгийн хуулийн[8] Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;

6.1.2.Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;

6.1.3.төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан;

6.1.4.хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;

6.1.5.үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;

6.1.6.Хүүхэд хамгааллын тухай хуулийн[9] 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

6.2.Доор дурдсан хүүхдэд түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж болно:

---

[8]Эрүүгийн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.
[9]Хүүхэд хамгааллын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

6.2.1.гэмт хэргийн гэрч хүүхэд;

6.2.2.Зөрчлийн тухай хуулийн[10] 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/, 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/-д заасан зөрчлийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхэд.

6.3.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд[11] заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хүсэлтийн дагуу хууль зүйн туслалцаа үзүүлж болно.

6.4.Ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх энэ хуулийн 6.1.4, 6.1.5-д заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа авч болно.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан хүнд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүй, санхүү, төсвийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.6.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.3-т заасан хүрээнд хууль зүйн туслалцаа үзүүлж болно.

6.7.Төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүний төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.8.Энэ хуулийн 5.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөөг хүний төлбөрийн чадваргүй эсэхээс үл хамааран, энэ хуулийн 5.2.2-т заасан хууль зүйн зөвлөгөөг төлбөрийн чадваргүй хүнд үнэ төлбөргүй үзүүлж болно.

### 7 дугаар зүйл.Үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдлыг тодорхойлох

7.1.Төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгчийг дараах байдлаар тодорхойлно:

7.1.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн[12] 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн;

---

[10]Зөрчлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.
[11]Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 30 дугаарт нийтлэгдсэн.
[12]Нийгмийн халамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 08 дугаар нийтлэгдсэн.

7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болох нь тухайн иргэний өргөдөл болон баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримтаар тогтоогдсон иргэн.

7.2.Хууль зүйн туслалцаа хүсэх өргөдлийн загварыг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал батална.

7.3.Энэ хуулийн 7.1.2-т заасан үйлчлүүлэгч төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

7.4.Төлбөрийн чадваргүй болохоо үнэн зөв мэдүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар үйлчлүүлэгчид урьдчилан бичгээр сануулна.

7.5.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй байдал, эсхүл энэ хуульд заасан хууль зүйн туслалцаа авах хүнд хамаарах өргөдлийн мэдээллийг шалгах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн[13] 3.1.5-д заасан улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан, Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан өрхийн мэдээллийн нэгдсэн санг хуульд заасны дагуу ашиглах, шаардлагатай тохиолдолд хүн, хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл, лавлагаа авах эрхтэй.

7.6.Энэ хуулийн 7.5-д заасан мэдээлэл, лавлагааг холбогдох хүн, хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан үнэн зөв, үнэ төлбөргүй, ажлын гурван өдрийн дотор гаргаж өгөх үүрэгтэй.

7.7.Хүн, хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 7.6-д заасан мэдээлэл, лавлагааг үнэн зөв гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

7.8.Үйлчлүүлэгч төлбөрийн чадвартай болох нь нотлогдвол улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө.

7.9.Энэ хуулийн 7.8-д заасан хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргахтай холбогдох харилцааг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрмээр зохицуулна.

[13]Улсын бүртгэлийн ерөнхий хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

**8 дугаар зүйл.Өмгөөллийн үйлчилгээ авахад бүрдүүлэх баримт бичиг**

8.1.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан үйлчлүүлэгч өмгөөллийн үйлчилгээ авах бол хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад өргөдөл гаргах бөгөөд дараах баримт бичгийг хавсаргана:

8.1.1.энэ хуулийн 7.1.1-д заасан мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй үйлчлүүлэгчийн хувьд баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, бусад нотлох баримт бичиг;

8.1.2.энэ хуулийн 6.4, 6.6-д заасан хүний хувьд холбогдох нотлох баримт бичиг;

8.1.3.энэ хуулийн 6.1.6-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд бол эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

8.1.4.энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.2-т заасан хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлт;

8.1.5.энэ хуулийн 6.3-т заасан гэрч, хохирогчийн хүсэлт;

8.1.6.хууль тогтоомж болон хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрэмд заасан бусад.

8.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага энэ хуулийн 7.1.1-д заасан мэдээллийг өрхийн мэдээллийн нэгдсэн сангаас татан авч, бүрдүүлэх бөгөөд үйлчлүүлэгчээс шаардахгүй.

8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын өмгөөлөгчөөс бусад өмгөөлөгч төлбөрийн чадваргүй хүнд хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэхдээ энэ хуульд заасан журмыг баримталж болно.

**9 дүгээр зүйл.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг**

9.1.Үйлчлүүлэгч дараах эрхтэй:

9.1.1.хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах;

9.1.2.улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийн талаар хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад, өмгөөллийн үйлчилгээний талаар холбогдох эрх бүхий байгууллагад, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын шийдвэр, үйл

ажиллагааны талаар хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус гомдол гаргаж шийдвэрлүүлэх, шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргах;

9.1.3.хуульд заасан бусад.

9.2.Үйлчлүүлэгч энэ хуулийн 7.3-т заасан үүргээ биелүүлээгүй бол хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

### 10 дугаар зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын удирдлага, зохион байгуулалт

10.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.

10.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага ажлын алба, салбараас бүрдэнэ.

10.3.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах болон судалгааны нэгжтэй байж болно.

10.4.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын ажлын алба /цаашид “ажлын алба” гэх/ хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.5.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын салбар /цаашид “салбар” гэх/ энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хууль зүйн туслалцааг үзүүлнэ.

10.6.Салбарт улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслах ажиллах бөгөөд салбарыг улсын ахлах өмгөөлөгч удирдана.

10.7.Улсын өмгөөлөгч нь ажил үүргийн болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны зарчмаар зохион байгуулагдан ажиллана.

10.8.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.9.Салбар нь албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

10.10.Улсын өмгөөлөгч хувийн тэмдэг болон салбарын албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.11.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаатай холбоотой асуудлыг уялдуулан зохицуулах зорилгоор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, прокурор болон цагдаагийн байгууллага, Монголын Нотариатчдын Танхим, Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, хууль зүйн туслалцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан орон тооны бус зөвлөлтэй байж болно.

10.12.Энэ хуулийн 10.11-д заасан орон тооны бус зөвлөлийн ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.13.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаа ил тод байна.

**11 дүгээр зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын чиг үүрэг**

11.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

11.1.2.хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах;

11.1.3.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;

11.1.4.улсын өмгөөлөгчийн хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалтыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.1.5.салбар байгуулагдаагүй нутаг дэвсгэрт хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;

11.1.6.улсын өмгөөлөгчдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

11.1.7.хүний нөөц, дэд бүтэц, техник тоног төхөөрөмжөөр хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

11.1.8.хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, дүн шинжилгээ хийх, нийтэд мэдээлэх;

11.1.9.чиг үүргийн хүрээнд гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;

11.1.10.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг нийтэд сурталчлах;

11.1.11.эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах, бусад байгууллагатай хамтран ажиллах;

11.1.12.хуульд заасан бусад.

11.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрэмд дараах зүйлийг тусгана:

11.2.1.ажлын алба болон салбарын чиг үүрэг;

11.2.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт;

11.2.3.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал, салбарын улсын ахлах өмгөөлөгчийн захиргааны чиг үүрэг;

11.2.4.улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах ажлын зохион байгуулалт;

11.2.5.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын бэлгэдэл, энгэрийн тэмдэг хэрэглэх заавар;

11.2.6.хуульд заасан бусад.

**12 дугаар зүйл.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал, түүний бүрэн эрх**

12.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал энэ хууль болон хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

12.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрмийг боловсронгуй болгох санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

12.2.2.тухайн нутаг дэвсгэр дэх хүн амын тоо, гэмт хэргийн гаралт, төлбөрийн чадваргүй, хууль зүйн туслалцаа авах шаардлагатай хүний эзлэх хувь, улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал зэргийг харгалзан салбарт ажиллах улсын өмгөөлөгчийн орон тоог тогтоох, салбар байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах зэрэг асуудлаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

12.2.3.ажлын алба, салбарын үйл ажиллагаанд хяналт тавьж, чиглэл өгөх;

12.2.4.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, сайжруулахтай холбоотой арга хэмжээний санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

12.2.5.улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн туслах, ажлын алба, нэгжийн удирдах, гүйцэтгэх болон туслах албан тушаалтныг томилох, чөлөөлөх;

12.2.6.өмгөөллийн үйлчилгээний хувийн хэрэг бүрдүүлэх, тайлагнах журам, өмгөөллийн үйлчилгээний тайлангийн загварыг батлах;

12.2.7.улсын өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзсан шийдвэрийг хянах, энэ талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;

12.2.8.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дотоод дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих;

12.2.9.улсын өмгөөлөгчийн цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлсний талаар санал боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулж, шийдвэрлүүлэх;

12.2.10.хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбоотой гэрээ байгуулах;

12.2.11.улсын өмгөөлөгчийн тухайн нутаг дэвсгэрт нүүдэллэн ажиллах хуваарь, удирдамжийг салбарын саналыг үндэслэн батлах;

12.2.12.энэ хуулийн 12.2.5-д заасан ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, олгох урамшуулал, хөнгөлөлт, тусламж, тэтгэмжийн хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу тогтоох;

12.2.13.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дотоод зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

12.2.14.хуульд заасан бусад.

**13 дугаар зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

13.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль зүйн туслалцааны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих;

13.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, боловсронгуй болгох санал боловсруулах;

13.1.3.хууль зүйн туслалцааны хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг хангуулах;

13.1.4.хуульд заасан бусад.

**14 дүгээр зүйл.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

14.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн туслалцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын бүтэц, орон тоог батлагдсан төсвийн хүрээнд тогтоох;

14.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирлыг томилох, чөлөөлөх;

14.1.3.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын саналыг үндэслэн батлагдсан төсвийн хүрээнд салбарын тоо, байршил, орон тоог тогтоох, салбарыг шинээр байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах;

14.1.4.улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчтэй болон хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага хувийн өмгөөлөгчтэй байгуулах гэрээний загвар, хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийн загварыг батлах;

14.1.5.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалыг батлах;

14.1.6.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын дүрэм, улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулах журам болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журмыг батлах;

14.1.7.хуульд заасан бусад.

**15 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

15.1.Засгийн газар хууль зүйн туслалцааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1.хууль зүйн туслалцааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.2.улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгчийн албан тушаалын цалингийн хэмжээг прокурорын албан тушаалын цалинтай дүйцүүлэх зарчмыг баримтлан цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүрийг батлах;

15.1.3.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын удирдах, гүйцэтгэх болон туслах албан тушаал, улсын өмгөөлөгчийн туслахын албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн тогтоох;

15.1.4.энэ хуулийн 19.1.3-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг батлах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧ, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ, БАТАЛГАА, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

### 16 дугаар зүйл.Улсын өмгөөлөгч

16.1.Улсын өмгөөлөгч энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй, хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай хөдөлмөрийн гэрээ байгуулсан албан хаагч байна.

16.2.Улсын өмгөөлөгч нь мэргэжлийн үйл ажиллагааг хараат бусаар явуулах бөгөөд аливаа этгээд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

### 17 дугаар зүйл.Улсын өмгөөлөгчийн чиг үүрэг

17.1.Улсын өмгөөлөгч дараах чиг үүрэгтэй:

17.1.1.үйлчлүүлэгчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх;

17.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах, холбогдох бүртгэлийг хөтлөх;

17.1.3.холбогдох журмын дагуу хэргийн хувийн хэргийг бүрдүүлж, өмгөөллийн үйлчилгээний тайланг баталсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд тайлагнах;

17.1.4.хуульд заасан бусад.

### 18 дугаар зүйл.Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

18.1.Улсын өмгөөлөгчид дараах үйл ажиллагааг хориглоно:

18.1.1.энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур өмгөөллийн үйл ажиллагаа явуулах;

18.1.2.хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээний болон хуульчийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуульт ажилд хамаарахаас бусад ажил, албан тушаал эрхлэх;

18.1.3.мэдээлэл, лавлагааг энэ хуулийн 7.5-д зааснаас бусад зорилгоор ашиглах;

18.1.4.үйлчлүүлэгчээс үйлчилгээ үзүүлсний төлөө өмгөөллийн хөлс, бусад төлбөр шаардах, авах;

18.1.5.хуульд заасан бусад.

18.2.Улсын өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу явуулна.

**19 дүгээр зүйл.Улсын өмгөөлөгчийн ажиллах нөхцөл, баталгаа**

19.1.Улсын өмгөөлөгч нь Төрийн албаны тухай хууль[14] болон холбогдох бусад хуульд заасан баталгаанаас гадна дараах нэмэлт баталгаагаар хангагдана:

19.1.1.өмгөөлөгчийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангагдах;

19.1.2.жил бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, оношилгоонд төрийн зардлаар хамрагдах;

19.1.3.аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа улсын өмгөөлөгчид таван жил тутамд 12 сарын, аймгийн төв, алслагдсан дүүрэгт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа улсын өмгөөлөгчид таван жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох;

19.1.4.хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсны төлөө хариуцлага хүлээхгүй байх;

19.1.5.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуульд заасан гишүүний татвар, өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын хураамж, хуульчийн үргэлжилсэн сургалтын төлбөрөөс улсын өмгөөлөгчөөр ажиллах хугацаанд чөлөөлөгдөх.

19.2.Энэ хуулийн 19.1.5-д заасан зардлыг төр хариуцна.

19.3.Улсын өмгөөлөгч нь ажиллаж байх хугацаандаа хуульчийн үргэлжилсэн сургалтад үнэ төлбөргүй хамрагдана.

[14]Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

19.4.Улсын өмгөөлөгчөөр гурван жил тасралтгүй ажилласан албан хаагчийг цэргийн албыг дүйцүүлэн хаасанд тооцно.

19.5.Улсын өмгөөлөгчөөр үүрэгт ажилд нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## ХУВИЙН ӨМГӨӨЛӨГЧИЙГ ОРОЛЦУУЛАХ

### 20 дугаар зүйл.Хувийн өмгөөлөгчийг оролцуулах нөхцөл

20.1.Доор дурдсан нөхцөл байдал үүссэн бөгөөд улсын өмгөөлөгч хүрэлцээгүй үед хувийн өмгөөлөгчийг ажиллуулж болно:

20.1.1.Өмгөөллийн тухай хуулийн 15.2-т заасан үндэслэлээр улсын өмгөөлөгч үйлчлүүлэгчид хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх боломжгүй бол;

20.1.2.нэг хэрэгт харилцан эсрэг сонирхолтой хоёр ба түүнээс дээш үйлчлүүлэгч хууль зүйн туслалцаа хүсэх өргөдөл гаргасан бол;

20.1.3.үйлчлүүлэгч нь холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу улсын өмгөөлөгчөөс татгалзсан бол.

20.2.Тухайн нутаг дэвсгэрт салбар байгуулагдаагүй, эсхүл улсын өмгөөлөгчийн ажлын дундаж ачаалал хоёр дахин болон түүнээс дээш хэмжээгээр нэмэгдсэн тохиолдолд хувийн өмгөөлөгчтэй гэрээ байгуулан ажиллуулж болно.

20.3.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх өмгөөлөгчдөөс сонгон, гэрээ байгуулсны үндсэн дээр хувийн өмгөөлөгчийг ажиллуулна.

20.4.Энэ хуулийн 20.3-т заасан өмгөөлөгч байхгүй бол тухайн орон нутгийн өмгөөлөгчдийн салбар зөвлөлийн гишүүн өмгөөлөгчдөөс, эсхүл нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн өмгөөлөгчийг сонгоно.

20.5.Өмгөөллийн тухай хуулийн 29.1-д заасан өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хувийн өмгөөлөгчийн энэ хуулийн 20.3-т заасан хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаатай уялдуулан зохицуулна.

20.6.Энэ хуулийн 20.4-т заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн хөлсний жишгийг улсын өмгөөлөгчийн цалин хөлсний жишгийг харгалзан хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

**21 дүгээр зүйл.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн хөлс**

21.1.Хувийн өмгөөлөгч нь хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хийсэн өмгөөллийн хувийн хэргийг холбогдох журмын дагуу бүрдүүлж, тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад ирүүлнэ.

21.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь энэ хуулийн 21.1-д заасан баримт бичгийг үндэслэн гэрээг дүгнэх бөгөөд энэ нь өмгөөллийн хөлс олгох үндэслэл болно.

21.3.Хувийн өмгөөлөгчийн өмгөөллийн хөлсийг энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**
**ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ, БУСАД БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО**

**22 дугаар зүйл.Санхүүжилтийн эх үүсвэр**

22.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд төсөв нь хууль зүйн туслалцааны үйл ажиллагааг хүртээмжтэй, шуурхай, тасралтгүй, үр дүнтэй явуулах шаардлагыг хангасан байна.

22.2.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд зориулан хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс буцалтгүй тусламж, хандив авч болно.

**23 дугаар зүйл.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах**

23.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ:

23.1.1.салбарыг стандартын шаардлага хангасан ажлын байр, техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах;

23.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тухайн нутаг дэвсгэрт ажиллахаар томилогдсон улсын өмгөөлөгчийг орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх.

23.2.Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга иргэний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын салбарын өмгөөлөгч, ажилтныг орон сууц, тээврийн хэрэгслээр хангах, улсын өмгөөлөгч, түүний гэр бүлийн гишүүнд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно.

**24 дүгээр зүйл.Хуульчдын холбооноос хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах**

24.1.Хуульчдын холбоо нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах байдлаар хамтран ажиллана:

24.1.1.улсын өмгөөлөгчийг хуульчийн үргэлжилсэн болон мэргэшүүлэх сургалт зохион байгуулахад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

24.1.2.хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах.

24.2.Улсын өмгөөлөгчийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад ирүүлнэ.

**25 дугаар зүйл.Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагатай харилцах**

25.1.Монголын Өмгөөлөгчдийн Холбоо хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дараах байдлаар хамтран ажиллана:

25.1.1.Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын үйл ажиллагаатай уялдуулах;

25.1.2.улсын өмгөөлөгчид үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох.

25.2.Энэ хуулийн 25.1.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагын захирал, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны ерөнхийлөгч хамтран батална.

25.3.Улсын өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, дуусгавар болгосон, түдгэлзүүлсэн бол шийдвэрийг гарсан өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад ирүүлнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 26 дугаар зүйл.Хууль зүйн туслалцааны мэдээллийн сан

26.1.Хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллага нь хууль зүйн туслалцааны мэдээллийн сантай байна.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хамгаалах, мэдээлэл солилцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.3.Мэдээллийн санд холбогдох байгууллага болон өмгөөлөгчийн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлсэн тухай мэдээллийг оруулах үүрэгтэй.

26.4.Өмгөөлөгчийн өмгөөллийн үйл ажиллагааг тогтмол эрхлэх нутаг дэвсгэр, ажлын байрны хаяг, утас, цахим шуудангийн хаягийг Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос хууль зүйн туслалцаа үзүүлэх байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.

### 27 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

27.3.Энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан улсын өмгөөлөгчтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчилтэй холбогдсон аливаа үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

**28 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

28.1.Энэ хуулийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠄ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠭᠡᠨ ᠦ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ

᠓.᠑. ᠲᠣᠷᠣ ᠶᠢᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶ᠋ᠢ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠳᠦ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶ᠋ᠢ ᠡᠨᠡ ᠬᠢ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠯᠳᠠ ᠶ᠋ᠢ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠨ᠎ᠠ ᠃

᠓.᠒. ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠕.᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠤᠨ ᠑.᠖ - ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠢ ᠲᠣᠳᠤᠷᠬᠠᠢᠯᠠᠨ ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠄ ᠲᠣᠳᠤᠷᠬᠠᠢᠯᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠢᠶ᠎ᠠ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠯᠠᠯ ᠤᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠶ᠋ᠢ ᠡᠷᠬᠢᠯᠡᠨ᠎ᠡ ᠃

᠔ ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠄ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ

᠔.᠑. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶ᠋ᠢ ᠡᠨᠡ / ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ / ᠲᠤᠰᠬᠠᠢ « ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ » ᠶᠢᠨ / ᠲᠣᠷᠣ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠲᠣᠷᠣ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠲᠡᠭᠦᠨ ᠦ ᠬᠡᠷᠡᠭᠡ ᠳᠦ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠃

᠔.᠑.᠑. ᠲᠣᠷᠣ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠡᠭᠡᠳᠦ ᠄ ᠲᠥᠪ ᠤᠨ ᠪᠠ ᠣᠷᠣᠨ ᠨᠤᠲᠤᠭ ᠤᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠃
᠔.᠑.᠒. ᠶᠠᠮᠠᠨ ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠪᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠄
᠔.᠑.᠓. ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠄ ᠴᠡᠴᠡᠷᠯᠢᠭ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠄
᠔.᠑.᠔. ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ ᠄ ᠬᠦᠮᠦᠵᠢᠯ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠄

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ
ᠬᠠᠮᠠᠭᠠᠯᠠᠬᠤ ᠪᠣᠳᠤᠯᠭ᠎ᠠ

᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠄ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ

᠕.᠑. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠬᠡᠷᠡᠭᠯᠡᠭᠡ ᠶ᠋ᠢ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ᠄

᠕.᠑.᠑. ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠦᠨ ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠄

[illegible]

᠑ ·᠑ · [illegible]

᠑ ·᠒ · [illegible]

᠑ ·᠓ · [illegible]

᠒ [illegible]

᠒ · [illegible]:

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠗.᠑.᠒. ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠔, ᠖.᠖-ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]᠃

᠗.᠑.᠓. ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠑.᠖-ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]
[illegible]᠃

᠗.᠑.᠔. ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠑.᠑, ᠖.᠑.᠒, ᠖.᠒-ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]
[illegible]᠃

᠗.᠑.᠕. ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠖.᠓-ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]᠃

᠗.᠑.᠖. [illegible] ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ [illegible] ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]᠃

᠗.᠒. [illegible] ᠡᠨᠡ ᠬᠠᠭᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠘.᠑.᠑-ᠳᠤ ᠵᠢᠭᠠᠭᠰᠠᠨ [illegible]
[illegible]᠃

᠗.᠓. [illegible]
[illegible]᠃

᠘ ᠳᠤᠭᠠᠷ ᠪᠦᠯᠦᠭ [illegible] ᠡᠷᠬᠡ᠂ [illegible]

᠘.᠑. [illegible] ᠡᠷᠬᠡ [illegible]:

᠘.᠑.᠑. [illegible]᠃

᠘.᠑.᠒. [illegible]
[illegible]
[illegible]
[illegible]᠃

[illegible]

᠑᠑.᠑.᠒. [illegible]

᠑᠑.᠑.᠓. [illegible]

᠑᠑.᠑.᠔. [illegible]

᠑᠑.᠑.᠕. [illegible]

᠑᠑.᠑.᠖. [illegible]

᠑᠑.᠑.᠗. [illegible]

᠑᠑.᠑.᠘. [illegible]

᠑᠑.᠑.᠙. [illegible]

᠑᠑.᠑.᠑᠐. [illegible]

᠑᠑.᠑.᠑᠑. [illegible]

᠑᠑.᠑.᠑᠒. [illegible]

᠑᠑.᠒. [illegible]:

᠑᠑.᠒.᠑. [illegible]

᠑᠑.᠒.᠒. [illegible]

᠑᠒.᠒.᠕. [illegible]

᠑᠒.᠒.᠖. [illegible]

᠑᠒.᠒.᠗. [illegible]

᠑᠒.᠒.᠘. [illegible]

᠑᠒.᠒.᠙. [illegible]

᠑᠒.᠒.᠑᠐. [illegible]

᠑᠒.᠒.᠑᠑. [illegible]

᠑᠒.᠒.᠑᠒. [illegible]

᠑᠒.᠒.᠑᠓. [illegible]

᠑᠒.᠒.᠑᠔. [illegible] ::

᠑᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ

ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ᠂ ᠠᠷᠠᠳ ᠪᠠ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠨ ᠪᠠᠢᠴᠠᠭᠠᠬᠤ ᠲᠠᠯᠠᠭᠠᠷ

᠑᠗.᠑.᠔. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠖.᠑.᠓–ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠯ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠯᠲᠡ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠃

᠑᠗.᠑.᠓. ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠳᠦ ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠡᠷ ᠠᠵᠢᠯᠯᠠᠬᠤ᠂ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠳᠦ ᠬᠠᠮᠲᠤ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠪᠣᠯᠭᠠᠬᠤ᠂ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠂

ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠲᠥᠯᠥᠭ ᠦᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ᠂

᠑᠗.᠑.᠕. ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠣᠬᠢᠶᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ

᠑᠗.᠑.᠑. ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ᠂

᠑᠗.᠑. ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ᠄

᠑᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠥᠷᠥ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ

᠑᠘.᠑.᠒. ᠠᠯᠪᠠᠨ ᠳᠤ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ᠃

ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠵᠠᠭᠠᠰᠠᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ᠂ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠂

᠑᠘.᠑.᠖. ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ

ᠪᠠᠢᠭᠤᠯᠬᠤ᠂

᠑᠘.᠑.᠗. ᠠᠯᠪᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ᠂ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ ᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠬᠦ ᠶᠢ

᠑᠕ · ᠑ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯ ᠢ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ ᠤᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠮᠵᠢ ᠮᠡᠳᠡᠬᠦ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠪᠤᠰᠤᠳ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠢ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠪᠦᠬᠦᠢ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠲᠤᠰᠢᠮᠡᠯ ᠦᠨ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ ᠪᠠᠢᠨ᠎ᠠ ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠢ ᠪᠡᠯᠡᠳᠬᠡᠬᠦ ᠳᠦ ᠪᠠᠢᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠰᠠᠨᠠᠯ ᠢ ᠲᠤᠰᠬᠠᠨ ᠲᠤᠰᠭᠠᠭᠠᠷ ᠲᠤᠰᠭᠠᠬᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠕ · ᠒ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠥᠯ ᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠶᠠᠪᠤᠴᠠ ᠳᠤ ᠬᠠᠷᠭᠠᠯᠵᠠᠬᠤ ᠪᠤᠶᠤ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠳᠤ ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠭᠤᠯᠤᠨ ᠲᠠᠨᠢᠯᠴᠠᠭᠤᠯᠤᠨ᠎ᠠ ᠃

᠑᠖ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠯᠲᠡ ᠬᠢᠬᠦ

᠑᠖ · ᠑ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠦᠨᠡᠯᠡᠯᠲᠡ ᠳᠦ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠬᠠᠮᠤᠷᠤᠨ᠎ᠠ ᠄

᠑᠖ · ᠑ · ᠑ · ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠣᠷᠢᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠰᠡᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠃

᠑᠖ · ᠑ · ᠒ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠠᠩᠭᠠᠬᠤ ᠵᠠᠷᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠃ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠤᠨ ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠃

᠑᠖ · ᠑ · ᠓ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠣᠨᠣᠪᠴᠢᠲᠠᠢ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠵᠣᠷᠢᠯᠭ᠎ᠠ ᠪᠠ ᠬᠠᠮᠤᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠢᠶ᠎ᠡ ᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠢ ᠬᠠᠷᠢᠯᠴᠠᠭ᠎ᠠ ᠃ ᠵᠣᠬᠢᠴᠠᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯ ᠪᠤᠶᠤ ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠴᠡᠭᠡ ᠃

᠑᠖ · ᠑ · ᠔ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠠᠬᠢᠴᠠ ᠃

᠑᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠢ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠬᠦ ᠶᠠᠪᠤᠴᠠ

᠑᠗ · ᠑ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠬᠡᠯᠡᠯᠴᠡᠬᠦ ᠳᠦ ᠳᠠᠷᠠᠭᠠᠬᠢ ᠵᠦᠢᠯ ᠢ ᠬᠠᠩᠭᠠᠨ᠎ᠠ ᠄

᠑᠗ · ᠑ · ᠑ · ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠳᠠᠭᠰᠠᠨ ᠵᠣᠷᠢᠯᠭ᠎ᠠ ᠪᠠᠷ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠰᠡᠨ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢ ᠲᠣᠭᠣᠷᠢᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠦᠷ᠎ᠡ ᠳᠦᠩ ᠢ ᠲᠣᠪᠴᠢᠯᠠᠬᠤ ᠃

᠑᠗ · ᠑ · ᠒ · ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠨᠥᠯᠥᠭᠡᠯᠡᠭᠰᠡᠨ ᠬᠦᠴᠦᠢᠯ ᠃ ᠰᠠᠭᠠᠳ ᠪᠡᠷᠬᠡᠰ ᠢ ᠲᠣᠭᠣᠷᠢᠭᠤᠯᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠶᠢ ᠰᠠᠢᠵᠢᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠵᠠᠮ ᠢ ᠲᠣᠭᠣᠷᠢᠭᠤᠯᠬᠤ ᠃ ᠰᠠᠨᠠᠯ ᠵᠥᠪᠯᠡᠮᠵᠢ ᠪᠣᠯᠪᠠᠰᠤᠷᠠᠭᠤᠯᠬᠤ ᠃

[illegible]

20.3. [illegible]

20.4. [illegible]

20.5. [illegible]

20.6. [illegible]

21 [illegible]

21.1. [illegible]

21.2. [illegible]

21.3. [illegible]

[illegible]

᠒᠖.᠒. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠪᠣᠯᠤᠨ ᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠦᠦᠷᠭᠡ ᠪᠡᠨ ᠭᠦᠢᠴᠡᠳᠭᠡᠬᠦ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠠᠪᠤᠷᠢ ᠬᠢᠬᠦ ᠂ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠲᠠᠯᠠᠪᠤᠷᠢ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ::

᠒᠖.᠓. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ ᠑᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠳᠦ ᠵᠠᠰᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠠᠮᠲᠤ ᠵᠢᠯ ᠦᠨ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠡ ᠬᠢᠭᠡᠳ ᠪᠠᠢᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠬᠦᠮᠦᠨ ᠪᠣᠯᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠨ᠎ᠡ ::

᠒᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ :: ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠬᠤ

᠒᠗.᠑. ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠢ ᠒᠐᠒᠒ ᠣᠨ ᠤ ᠑᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠐᠑ – ᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ ::

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ
ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠊ ᠵᠠᠩᠳᠠᠨᠰᠠᠲᠤ

[illegible] :

᠑ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠑᠙᠙᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠒ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠕ ᠣᠨ ᠤ ᠒᠓ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠓ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠕ ᠣᠨ ᠤ ᠒᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠔ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠐᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠕ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠙ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠖ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠒ ᠣᠨ ᠤ ᠑᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠗ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠙ ᠣᠨ ᠤ ᠔᠙ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠘ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠕ ᠣᠨ ᠤ ᠐᠕ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠙ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠖ ᠣᠨ ᠤ ᠐᠙ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠑᠐ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠕ ᠣᠨ ᠤ ᠒᠔ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠑᠑ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠓ ᠣᠨ ᠤ ᠓᠐ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠑᠒ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠒ ᠣᠨ ᠤ ᠐᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠑᠓ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠗ ᠣᠨ ᠤ ᠒᠗ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

᠑᠔ . [illegible] « ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ » ᠡᠮᠬᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠒᠐᠑᠗ ᠣᠨ ᠤ ᠐᠑ ᠳᠤᠭᠠᠷ ᠲᠤ ᠨᠡᠢᠲᠡᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ::

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

## ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ЯЛЛАГДАГЧИД ҮЗҮҮЛЭХ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

2022 ᠣᠨ ᠤ 07 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 01 – ᠦ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠴᠢᠳᠠᠪᠤᠷᠢ ᠦᠭᠡᠢ ᠶᠠᠯᠠᠯᠠᠭᠳᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

1 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ 2013 ᠣᠨ ᠤ 07 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 05 – ᠤ ᠡᠳᠦᠷ ᠪᠠᠲᠤᠯᠠᠭᠰᠠᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠴᠢᠳᠠᠪᠤᠷᠢ ᠦᠭᠡᠢ ᠶᠠᠯᠠᠯᠠᠭᠳᠠᠭᠴᠢ ᠳᠤ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠠᠷᠠᠢ᠃

2 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠨ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠃ ᠽᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

## ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.11 дэх заалтын “ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг” гэснийг “ажиллагаа” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

## ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

2022 ᠣᠨ ᠤ 07 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 01 - ᠦ ᠡᠳᠦᠷ ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠬᠠᠤᠯᠢᠴᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

1 ᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠬᠠᠤᠯᠢᠴᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 45 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 45.1.11 ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ « ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠪᠣᠯᠣᠨ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠶᠢᠨ ᠴᠢᠳᠠᠪᠤᠷᠢ ᠦᠭᠡᠢ ᠢᠷᠭᠡᠳ ᠲᠦ ᠥᠮᠥᠭᠡᠯᠡᠯ ᠦᠨ ᠦᠢᠯᠡᠴᠢᠯᠡᠭᠡ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ ᠠᠵᠢᠯ ᠢ » ᠭᠡᠰᠡᠨ ᠢ « ᠠᠵᠢᠯᠯᠠᠭ᠎ᠠ » ᠭᠡᠵᠦ ᠥᠭᠡᠷᠡᠴᠢᠯᠡᠰᠦᠭᠡᠢ ᠃

2 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠬᠠᠤᠯᠢᠴᠢ ᠶᠢᠨ ᠡᠷᠬᠡ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠪᠠᠢᠳᠠᠯ ᠤᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 45 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 45.2 ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠢ ᠬᠦᠴᠦᠨ ᠦᠭᠡᠢ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠳᠤ ᠲᠣᠭᠠᠴᠠᠭᠰᠤᠭᠠᠢ ᠃

3 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ / ᠰᠢᠨᠡᠳᠭᠡᠨ ᠨᠠᠶᠢᠷᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ / ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠡᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

## ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.7 дахь хэсгийн “иргэнийг” гэснийг “иргэн болон Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 16.1-д заасан улсын өмгөөлөгчөөр гурван жил тасралтгүй ажилласан Хууль зүйн туслалцааны төвийн хуульчийг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР**

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

## ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 25.2.4 дэх заалт нэмсүгэй:

“25.2.4.хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** — **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

2022 ᠣᠨ ᠤ 07 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷ᠎ᠠ ᠶᠢᠨ 01 - ᠨ ᠡᠳᠦᠷ — ᠤᠯᠠᠭᠠᠨᠪᠠᠭᠠᠲᠤᠷ ᠬᠣᠲᠠ

ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠳᠤ ᠨᠡᠮᠡᠯᠲᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠨᠢᠭᠡᠳᠦᠭᠡᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠲᠥᠰᠥᠪ ᠦᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢᠨ 25 ᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ ᠦᠨ 25.2 ᠳᠠᠬᠢ ᠬᠡᠰᠡᠭ ᠲᠦ ᠳᠣᠣᠷ᠎ᠠ ᠳᠤᠷᠳᠤᠭᠰᠠᠨ ᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ ᠲᠠᠢ 25.2.4 ᠳᠡᠬᠢ ᠵᠠᠭᠠᠯᠲᠠ ᠨᠡᠮᠡᠭᠲᠡᠭᠡᠢ᠄

«25.2.4. ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢ ᠦᠨ᠎ᠡ ᠲᠥᠯᠥᠪᠦᠷᠢ ᠦᠭᠡᠢ ᠦᠵᠡᠭᠦᠯᠬᠦ᠃»

ᠬᠣᠶᠠᠳᠤᠭᠠᠷ ᠵᠦᠢᠯ᠃ ᠡᠨᠡ ᠬᠠᠤᠯᠢ ᠶᠢ ᠬᠠᠤᠯᠢ ᠵᠦᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠰᠠᠯᠠᠮᠵᠢ ᠶᠢᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠠᠤᠯᠢ /ᠰᠢᠨᠡᠳᠭᠡᠭᠰᠡᠨ ᠨᠠᠢᠷᠠᠭᠤᠯᠭ᠎ᠠ/ ᠬᠦᠴᠦᠨ ᠲᠡᠭᠦᠯᠳᠦᠷ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠳᠦᠷ ᠡᠴᠡ ᠡᠬᠢᠯᠡᠨ ᠳᠠᠭᠠᠵᠤ ᠮᠥᠷᠳᠡᠨ᠎ᠡ᠃

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠤᠷᠠᠯ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ — ᠭ᠂ ᠵᠠᠨᠳᠠᠨᠱᠠᠲᠠᠷ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн гарчгийн “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль зөрчих” гэснийг “Хууль зүйн туслалцааны тухай хууль зөрчих” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа яллагдагч” гэснийг “Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах хүн” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 72.1.6 дахь заалт нэмсүгэй:

“72.1.6.харьяалах нутаг дэвсгэртээ үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах, хэрэгжилтийг дүгнүүлэх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хууль зүйн туслалцааны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА — Г.ЗАНДАНШАТАР**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠬᠠᠤᠯᠢ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр — Дугаар 108 — Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Хорват Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ганхуурайн Баттунгалагийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Хорват Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Мижиддоржийн Цэнгэгийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар сарын 24-ний өдөр — Дугаар 113 — Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбын Ганхуягийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Пакистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түвшингийн Бадралыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

**Хаяг:**
"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeelel@parliament.mn
**Утас:** 262420
Хэвлэлийн хуудас: 6.5
**Индекс: 200003**